



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбулган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/10-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2025 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.ГАНЗОРИГ ТАНАА

2025.03.28 № 168
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Архангай аймгийн Эрдэнэбулган сумын сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Тайлант онд сумын төсвийн 19 нэр төрлийн орлогоор 10,820,168.2 мянган төгрөг төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 13,177,977.7 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөө нийт дүнгээр 121.8 хувиар давж биелжээ.

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд сумын ЗДТГ, ИТХ, ХТҮГ, ОНХС, ХХС-ийн санхүүгийн тайлан, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ-ийн тогтмол зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэгтгэсэн байна.

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, хот байгуулалт тохижилт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, ерөнхий боловсрол,

сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан 9,811,572.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 8,669,854.2 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 1,141,718.3 мянган төгрөг зарцуулагдаагүй байна. Үүнээс 669,981.8 мянган төгрөг нь ОНХС болон ХХС-ийн зарцуулагдаагүй үлдэгдэл бөгөөд 471,736.5 мянган төгрөг нь төсөвт байгууллагуудын ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн төсвийн үлдэгдэл байна.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэбулган сумын Засаг дарга нь 2024 онд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээгээр 15 үндсэн зорилтын хүрээнд 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 87.7 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,671,977.6	4,377,827.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,495,679.6	3,435,257.1
33	АВЛАГА	1,003,680.2	790,950.3
35	БАРАА МАТЕРИАЛ	132,306.9	132,930.3
36	НӨӨЦИЙН БАРАА	40,311.0	18,690.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	16,260,639.7	15,908,161.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	16,260,639.7	15,908,161.5
39200	Биет хөрөнгө	16,171,278.7	15,819,048.0
39300	Биет бус хөрөнгө	89,361.0	89,113.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	18,932,617.3	20,285,989.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	18,932,617.3	20,285,989.2
51	Засгийн газрын хувь оролцоо	18,932,617.3	20,285,989.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,590,312.8	2,590,312.8
51200	Хуримтлагдсан үр дүн	16,313,214.7	17,666,586.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	29,089.8	29,089.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	18,932,617.3	20,285,989.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,901,444.7	14,889,996.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,461,467.8	12,756,998.2
110	Орлогын албан татвар	7,444,310.0	11,710,458.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	7,438,089.5	11,705,910.3
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	6,220.4	4,548.4
113	Хөрөнгийн албан татвар	432,324.2	600,901.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	584,833.7	445,638.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,820,976.8	1,435,962.4
120	Нийтлэг татварын бус орлого	2,820,976.8	1,435,962.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	619,000.1	697,036.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,958,860.2	12,827,090.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,958,860.2	12,616,605.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,145,202.1	9,044,457.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,736,689.2	2,420,624.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	281,357.1	298,717.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,542.7	3,187,661.4
2104	Хангамж, бараа материалын зардал	40,980.4	55,666.6
2105	Нормативт зардал	12,995.0	9,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	125,237.4	600,536.4
2107	Томиллолт, зочны зардал	4,845.0	8,030.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,366,390.1	129,792.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,483,165.3	2,333,829.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	813,658.1	3,572,148.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	210,484.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,942,584.6	2,062,905.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,446,971.5	709,533.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,495,613.1	1,353,372.0

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	9,762,315.5	14,106,355.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,461,467.8	12,756,998.2
110	Орлогын албан татвар	7,444,310.0	11,710,458.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	7,438,089.5	11,705,910.3
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	6,220.4	4,548.4
113	Хөрөнгийн албан татвар	432,324.2	600,901.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	584,833.7	445,638.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	259,010.1	350,447.4
1181	Газрын төлбөр	325,823.6	95,190.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	681,847.5	652,321.1
120	Нийтлэг татварын бус орлого	681,847.5	652,321.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	619,000.1	697,036.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,124,765.7	11,223,212.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,124,765.7	11,223,212.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,311,107.6	7,651,064.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,736,689.2	2,421,424.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	281,357.1	298,717.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,790.7	3,183,633.4
2104	Хангамж, бараа материалын зардал	40,040.5	46,108.0
2105	Нормативт зардал	12,995.0	10,960.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	141,058.9	569,757.3
2107	Томилолт, зочны зардал	4,845.0	8,030.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,394,220.1	129,781.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	596,111.2	982,653.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	813,658.1	3,572,148.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,637,549.7	2,883,142.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,479,992.8	943,565.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,479,992.8	943,565.3
2200	Дотоод эх үүсвэрээр	1,479,992.8	943,565.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,479,992.8	-943,565.3
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-166,000.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	166,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	991,556.9	1,939,577.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	504,122.6	1,495,679.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,495,679.6	3,435,257.1

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,437,004.2	17,437,004.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	9,433.7	9,433.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,446,437.9	17,446,437.9
4	Өмчид гарсан өөрчлөлт	-9,433.7	-9,433.7
5	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
6	Тайлант үеийн үр дүн	1,495,613.1	1,495,613.1

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

7	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	18,932,617.3	18,932,617.3
8	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	18,932,617.3	18,932,617.3
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	18,932,617.3	18,932,617.3
10	Тайлант үеийн үр дүн	1,353,372.0	1,353,372.0
11	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,285,989.2	20,285,989.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,811,572,500.0	8,669,854,224.8	1,141,718,275.2	88.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,074,823,200.0	7,731,659,960.8	343,163,239.2	95.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,947,521,200.0	7,615,145,728.8	332,375,471.2	95.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,452,389,500.0	2,421,424,227.4	30,965,272.6	98.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	303,885,300.0	298,717,112.7	5,168,187.3	98.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,404,301,500.0	3,183,633,419.2	220,668,080.9	93.5
2104	Хангамж, бараа материалын зардал	49,774,900.0	46,613,005.0	3,161,895.0	93.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	575,634,400.0	574,623,340.0	1,011,060.0	99.8
	Нормативт зардал	11,000,000.0	10,960,000.0	40,000.0	99.6
2107	Томилолт, зочны зардал	10,000,000.0	8,030,000.0	1,970,000.0	80.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	145,040,600.0	119,461,331.0	25,579,269.0	82.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	995,495,000.0	951,683,293.5	43,811,706.5	95.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,302,000.0	116,514,232.0	10,787,768.0	91.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,302,000.0	86,514,232.0	9,787,768.0	89.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,302,749,300.0	938,194,264.0	364,555,036.0	72.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	434,000,000.0	-	434,000,000.0	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,811,572,500.0	8,948,035,721.8	863,536,778.3	91.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,989,080,700.0	8,666,713,164.8	(677,632,464.8)	108.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,822,491,800.0	281,322,557.0	1,541,169,243.1	15.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		344,306,577.8	(344,306,577.8)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		622,488,074.7	(622,488,074.7)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2		100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	61	57		93.4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	61	57		93.4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	41,489.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	41,489.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,289.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,319.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,970.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	200.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	41,489.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,489.6

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй. Харин залруулагдаагүй нийт 38,063.0 мянган төгрөгийн зөрчил² илэрч, 1 албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн 38,063.0 мянган төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлсэн бөгөөд аудитын төлөвлөлтийн үе шатанд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **68,681.0** мянган төгрөгөөс бага байгаа тул **Зөрчилгүй** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Хоршоо хөгжүүлэх сангаас 2018-2020 онуудад зээл авсан 7 иргэн, 1 хоршоотой холбоотой нийт 38,063.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 10 дугаар зүйлийн 10.1-т “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина.”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж, хугацаа хэтэрсэн зээлийг төвлөрүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ХХС	1	38,063.0			1	38,063.0						
Нийт дүн	1	38,063.0			1	38,063.0						

5. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ИТХ	2	2,518.0	1	478.0	1	2,040.0						
ЗДТГ	7	37,777.2	1	2,850.0	6	34,927.2						
ХТҮГ	5	210,004.8	1	361.1	4	209,643.7						
Нийт дүн	14	250,300.0	3	3,689.1	11	246,610.9						